

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Чогдонгийн НАРАНЦЭЦЭГ

НЯРАЙН ҮЖЛИЙН ЭРТ ОНОШЛОГОО

Е- 720136 Хүүхдийн анагаах

**Улаанбаатар хот
2006 он**

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Чогдонгийн НАРАНЦЭЦЭГ

НЯРАЙН ҮЖЛИЙН ЭРТ ОНОШЛОГОО

Е- 720136 Хүүхдийн анагаах

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

З.Гэрэлмаа – Анагаах ухааны доктор, клиникийн профессор

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

Д.Малчинхүү Анагаах ухааны доктор, профессор

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

С.Лхамсүрэн Анагаах ухааны доктор

Улаанбаатар хот
2006 он

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	1
Асуудлын тулгамдсан байдал	1
Судалгааны ажлын зорилго, зорилтууд	3
Судалгааны ажлын шинэлэг тал	3
Судалгааны ажлын практик ач холбогдол.....	3
Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал.....	4
Судалгааны ажлын бүтэц хэмжээ.....	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Хэвлэлийн тойм	4
1.1.Үжлийн тухай ойлголт	4
1.2.Үжил үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс	7
1.3.Халдварлах зам эх үүсвэр	8
1.4.Эмнэлзүйн хам шинж.....	8
1.5.Үжлийн оношлогоо.....	12
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй.....	15
2.1.Судалгааны загвар.....	15
2.2.Судалгааны материал ба мэдээлэл цуглуулсан арга	16
2.3.Судалгааны үзүүлэлтүүд.....	14
2.4.Судалгааны үр дүнгийн боловсруулалт	16

2.5.Нярайн нэр томъёоны тодорхойлолт.....	19
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Судалгааны ажлын үр дүн	20
3.1. Судалгаанд хамрагдагсдын ерөнхий тодорхойлолт.....	20
3.2. Эхийн талаас нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс.....	22
3.3. Хүүхдийн талаас нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс.....	27
3.4.Үжлийн илрэл.....	эмнэлзүйн 32
3.5. Лабораторийн үзүүлэлтүүд.....	35
3.6. Нярайн үжлийн эрт оношлогооны алгоритм....	38
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Үр дүнгийн хэлцэмж.....	39
ДҮГНЭЛТ.....	41
ПРАКТИК ЗӨВЛӨМЖ.....	42
НОМ ЗҮЙ.....	43
ХАВСРАЛТ.....	47

УДИРТГАЛ

Асуудлын тулгамдсан байдал

Хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын өсөлт, мэдрэл сэтгэцийн хөгжилд нярай үеийн¹ өвчлөл чухал нөлөө үзүүлдэг. Эхийн эрүүл мэнд, жирэмслэлт, төрөлтийн байдал, нийгэм ахуйн байдал, хүүхдийн төрөлхийн дархлаа дутмагшил гэх мэт олон хүчин зүйлээс хамаарч нярай хүүхэд эмгэг өвчтэй болох, халдварт өртөх, нас барах эрсдэл ихтэйг олон эрдэмтэн тэмдэглэсэн байдаг [1, 2, 6, 11, 24, 36, 71].

Дэлхийн хэмжээнд нялхсын эндэгдлийн гуравны хоёр, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 40 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна. Жил бүр ойролцоогоор 4 сая нярай хүүхэд эндэж буйн 2.8 сая буюу 70 хувь нь амьдралынхаа эхний долоо хоногт нас барж байгаагийн эндэгдлийн үндсэн шалтгаан нь дутуу төрөлттэй холбоотой байдлууд (35%), бүтэлт (29%), халдвар (16%), төрөлхийн гаж хөгжил (15%) тус тус орж байна. Үлдсэн 1.2 сая хүүхэд буюу 30 хувь нь 8–28 хоногтойдоо нас барж, эндэгдлийн үндсэн шалтгаанд халдвар (60%), дутуу төрөлттэй холбоотой байдлууд (19%), төрөлхийн гаж хөгжил (8%) эзэлж байна

[4, 6].

Монгол Улсын Засгийн газраас эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах талаар хэрэгжүүлсэн олон талт арга хэмжээний үр дүнд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл сүүлийн 10 гаруй жилд тогтвортой буурч байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээс харахад нялхсын эндэгдэл 1991 онд 1000 амьд төрөлтөд 63.4 байснаа 2005 онд 20.8 болж 42.6 пунктээр буурсан

[36, 39]. Харин нярайн эндэгдэл 1991 онд 1000 амьд төрөлтөд 20 байсан бол 2003 онд 12 болж 8 пунктээр буурсан хэдий ч нялхсын эндэгдлийн 47 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа нь [ЭМЯ, Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 1991-2005] перинаталь–нярайн тусламжийг онцгой анхаарах цаг болсныг харуулж байна.

ДЭМБ -ийн мэдээллээр нярайн эндэгдлийн үндсэн шалтгаан дотроос эхний байранд нярайн халдвар (32%), хоёрдугаарт бүтэлт (29%),

гуравдугаарт дутуу төрөлттэй холбоотой хүндрэл (24%), дөрөвдүгээрт төрөлхийн гаж хөгжил (10%), тавдугаарт бусад шалтгаан (5%) тус тус орж байна [ДЭМБ.2004].

Манай улсад нярайн эндэгдлийн шалтгааны нэгдүгээрт бүтэлт ба төрөлтийн гэмтэл (48%), хоёрдугаарт халдвар (22%), гуравдугаарт дутуу төрөлттэй холбоотой эмгэг (17%), дөрөвдүгээрт төрөлхийн гаж хөгжил (9%), тавдугаарт бусад эмгэг (4%) тус тус эзэлж байна [ЭМЯ.Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2004].

Үүнээс харахад нярайн халдвар нь дэлхийн хэмжээнд нярайн эндэгдлийн шалтгааны нэгдүгээрт, манай улсын хувьд хоёрдугаарт орж байна.

Үжлийн тархалт нь АНУ - д 1000 амьд төрөлтөд 1- 8 тохиолдол, манай улсад 3.31 тохиолдол байна [39, 51, 60]. Үжлээр өвчилсөн дөрвөн хүүхэд тутмын нэг нь мэнэнгээр хүндэрдэг байна. Мэнэнгийн тохиолдол нь 1000 амьд төрөлтөд ойролцоогоор нэг байх ба нас барах эрсдэл ихтэй (30-60%), эдгэрч гарсан хүүхдийн 50 хувьд нь мэдрэл сэтгэцийн эмгэг үлдэцтэй болдог байна. Улсын хэмжээнд нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг Эх Нялхсын Эрдэм Шинжилгээний Төвийн (ЭНЭШТ) Хүүхдийн Дотрын Клиникийн (ХДК) нярайн эмгэгийн тасагт 1997-2000 онд хэвтэж эмчлүүлэгсдийн дөрөвний нэг, эндэгдлийн гуравны нэгийг үжил эзэлж байна [6].

Нярайн эмгэгийн тасгийн тайлангаас харахад, ЭНЭШТ-ийн нярайн эмгэгийн тасагт 2001-2004 онд эмчлүүлэгсдийн өвчлөл ба эндэгдлийн бүтцэд нярайн халдварын эзлэх хувь өндөр байна [Зураг 1]. Улаанбаатар хотын амаржих газруудад хийсэн судалгаанаас үзэхэд нярайн халдвар нь гүйцэд нярайн эндэгдлийн шалтгааны гуравдугаарт, дутуу нярайн эндэгдлийн нэгдүгээрт орж байна. Дутуу нярайн эндэгдлийн хувь гүйцэд нярайнхаас 29 дахин өндөр, нярайн эндэгдлийн 98.9 хувийг эрт нярайн эндэгдэл эзэлж байна. [17]. Улсын хэмжээнд нярайн эндэгдлийн шалтгааны дөрөвдүгээрт ураг нярайн халдвар орж байна [16]. ЭНЭШТ-д ХДК-ийн нярайн тасгийн материалаас үзэхэд нярайн өвчлөлийн 31.3 хувийг нярайн халдвар эзэлж нас баралтын зонхилох шалтгааныг нярайн үжил (56.6 %), ургийн халдвар (15 %), уушгины үрэвсэл (10 %) эзэлж байна [15]. Дээр дурдсан баримтууд нь нярайн халдвар өндөр хувьтай байгааг гэрчилж байгаа бөгөөд энэхүү өвчнийг эрт оношилж эмчлээгүйгээс хүүхэд бие бялдар, мэдрэл сэтгэцийн өөрчлөлттэй, тахир дутуу болохоос гадна нас барах эрсдэл ихтэй байна.

Иймээс өвчлөл, эндэгдэлд зонхилж байгаа нярайн үжлийг эрт оношлон илрүүлж эмчлэх, тусламж үйлчилгээг оновчтой сайжруулах нь нялхсын өвчлөл эндэгдлийг бууруулах, улмаар амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн тулгамдсан асуудлын нэг болохыг өгүүлж байна.

Манай орны нөхцөлд нярайн үжлийн оношлогооны асуудлаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил хомс бөгөөд нярайн үжил үүсэхэд

нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс, хүүхдээс хамаарах онцлогууд, илрэх шинж тэмдгүүдийг судлах нь онол практикийн чухал ач холбогдолтой учраас энэхүү сэдвийг сонгон судалгаа хийлээ.

Судалгааны ажлын зорилго, зорилтууд

Судалгааны ажлын зорилго: Нярайн үжил үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс, үжлийн үед эрт илрэх шинж тэмдгийг тогтоох, эрт оношлогооны алгоритм боловсруулахад оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.Үүнд :

- Үжил үүсэхэд эхийн ба хүүхдийн талаас нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг судлах
- Нярайн үжлийн эмнэлзүйд эрт илрэх шинж тэмдгүүдийг тогтоох
- Үжлийн үед лабораторийн шинжилгээнд илрэх зарим өөрчлөлтийг тогтоож, нейтрофилийн абсолют тоо, нейтрофилийн залуу эсийг нийт нейтрофильд харьцуулсан харьцааг тодорхойлж Монрогийн хүснэгт ашиглаж харьцуулалт хийх, цусанд С-идэвхит уураг тодорхойлох, нян судлалын шинжилгээ хийх.
- Нярайн үжлийг эрт оношлох алгоритм боловсруулах.

Судалгааны ажлын шинэлэг тал

- Нярайн үжил үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс, үжлийн эрт оношлогооны асуудалд үжлийн шалгуур үзүүлэлтийг ашиглан манай орны нөхцөлд судалсан анхны ажил.
- Нейтрофилийн абсолют тоо, үжлийн шүүлтүүрийг тодорхойлон үжлээр өвчилсөн ба өвчлөөгүй нярайд тодорхойлж харьцуулан судалсан.
- Үжлийг эрт оношлох алгоритм боловсруулсан.

Судалгааны ажлын практик ач холбогдол

1. Үжлээр өвчлөхөд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг судалж тогтоосноор жирэмсний хяналтыг сайжруулах, охид эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээнд онцгой анхааран, халдварт өртөх эрсдэлийг багасгах ач холбогдолтой.
2. Үжлийг эрт оношлож, эмчилгээг эрт эхэлснээр нялхсын өвчлөл эндэгдлийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг сайжруулах боломжтой болно.
3. Үжлийг эрт оношлох алгоритм ашигласнаар үжил сэжигтэй нярайд цаг алдалгүй тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эмч мэргэжилтнүүд эзэмшин, улмаар үжлийн эндэгдлийг бууруулахад тодорхой нөлөө үзүүлнэ.
4. Манай орны нөхцөлд үжлээр өвчилсөн нярайд эх болон хүүхдийн талаас нөлөөлсөн эрсдэлт хүчин зүйлс, өвчин үүсгэгч, үжлийн эмнэлзүйн илрэл, эндэгдлийн байдал зэргийг бусад оронд хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулан дүгнэхэд ач холбогдолтой.

Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. Магистрын ажлын сэдэв, арга, аргачлалыг ЭМШУИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн хурлаар хэлэлцэж батлуулсан (2004.05.19. Хурлын протокол, №19).
2. ЭМШУИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн хурлаар судалгааны ажлын, үр дүнг хэлэлцүүлж урьдчилан хамгаалалтанд орохыг зөвшөөрсөн (Протокол №).
3. ЭМШУИС-ийн Биоанагаахын Ёс зүйн Зөвлөлийн хурлаар (2005.06.09. №15/5)
4. ЭМШУИС-ийн АУС-ийн Эрдэмтдийн Зөвлөлийн хурлаар урьдчилан хамгаалалтад орсон (2005.06.10.Протокол № 07).